

## **ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйл, заалтад тандан судалгаа хийв.

### **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 онд батлагдаж зээлдэгчийн зээлийн мэдээллийг хадгалах, ашиглах зохицуулалт бий болсноор банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн ба сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн салбарт учрах эрсдэлийг бууруулах ажлууд амжилттай хэрэгжиж ирсэн. Үүний нэг жишээ бол арилжааны банкнуудыг нээлттэй хувьцаат компани болгон хуульчилж банкны үйл ажиллагааг олон нийтийн хяналтын доор явуулах боломжийг бүрдүүлж өгсөн. Банк, санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна. Энэхүү салбарын үйлчилгээг их өгөгдөлд суурилсан байдлаар шийдвэрлэвэл салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэн цаашлаад зээлийн хүү бууруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

#### **1. Зээлжих зэрэглэлт тогтоох систем, бүтэцтэй болох шаардлага**

Зээлдэгчийн зээлийн мэдээллийг ашиглан арилжааны банкнууд өөрсдийн үйл ажиллагаанд нийцүүлэн тус бүрдээ харилцагчийн үнэлгээ хийж явсаар ирсэн. Нэг зээлдэгчийг тухайн арилжааны банк өөрсдийн аргачлалаар эрсдэл даах чадвар, үйл ажиллагааны онцлогоос хамааран үнэлж, зээлийн хүү, барьцаа хөрөнгө шаардах байдлыг ялгавартай тогтоож байна. Адилхан нэг зээлдэгчийн эрсдэлийн үнэлгээ хийхдээ мэдээллийн нэг эх сурвалж ашиглаж байгаа ч нэгдсэн аргачлал, журамгүйгээс болоод зээлдүүлэгч байгууллагууд харилцагчдад уяан хатан, таатай үйлчилгээ санал болгохгүй байна. Нэгдсэн аргачлал, журамтай болсноор зээлдэгч өөрсдийн зээлжих зэрэглэл буюу оноогоо нээлттэй мэдээлж хүссэн зээлдүүлэгч байгууллагаасаа өөрийн онцлогт нийцсэн үйлчилгээ авах боломжтой болох юм. Зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэлтэй болсноор санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах өндөр ач холбогдолтой.

#### **2. Зээлжих зэрэглэлт тогтоох нэгдсэн аргачлалыг төрийн тусгай эрх бүхий байгууллага батлах шаардаалга**

Олон улсад хадгаламжийн даатгалын байгууллагаас гадна зээл, санхүүжилтийн үйл ажиллагааг хянах, оролцогч талуудын эрх, ашийг хангуулах бодлогын байгууллагууд байдаг. Энэхүү байгууллагуудын чиг үүрэгт тухайн улсын хууль, тогтоомжид нийцүүлсэн өөрсдийн гэсэн зээлжих зэрэглэл тогтоох бодлого хэрэгжүүлэн ажилладаг байна.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох аргачлалыг батлах төрийн агентлагууд:

Улс	Байгууллагын нэр	Өмчийн хэлбэр
АНУ	Consumer Financial Protection Bureau (CFPD), Federal Trade Commission (FTC)	Төрийн өмч
Их британи	The Financial Conduct Authority (FCA)	Төрийн өмч
Канад	Financial Consumer Agency of Canada	Төрийн өмч
Австралиа	Australian Securities and Investments Commission	Төрийн өмч
Герман	Federal Financial Supervisory Authority	Төрийн өмч
Энэтхэг	Credit Information Bureau	Төрийн өмч
Япон	Financial Services Agency	Төрийн өмч

*Эх сурвалж: Дээрх төрийн агентлагуудын цахим хуудас*

Олон улсын жишгээр бодлого тодорхойлогч байгууллагууд нь зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох бодлого, аргачлал баталж, хэрэгжилтийг хянадаг буюу нэгдсэн бодлогоор зээлийн эргэн төлөлтийн байдал, зээл эрсдэлд орсон шалтгаан болон бусад зээлдэгчийн онцлогоос хамааран хэрхэн зээлдэгчийн үнэлгээг тогтоох аргачлал баталдаг байна.

### **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийг зээлдэгчийн банк, санхүүгийн салбараас хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх, зээлдэгчийн санхүүгийн сахилга бат, хариуцлагыг бий болгож тус салбарын тогтвортой байдлыг хадгалах замаар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой гэж тодорхойлов. Зээлдэгчийн зээлийн мэдээллийг ашиглаж зээлжих зэрэглэл буюу зээлдэгчийн онооны системийг бий болгох шаардлагатай бөгөөд тусгай эрх бүхий байгууллагаас холбогдох аргачлал, журмыг баталснаар нэгдсэн байдлаар зээлдэгчийн үнэлгээ тогтож “өндөр” зэрэглэл буюу үнэлгээтэй зээлдэгч өөрсдийн шаардлагад нийцүүлэн банк, санхүүгийн салбараас хамгийн уян хатан нөхцөлтэй үйлчилгээ авах боломжтой болно. Хуулийн төсөл болон уг судалгааны зорилго нь зээлжих зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагыг тодорхойлж зээлдэгчийн банк, санхүүгийн салбараас хүртэх хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлдэгчийн санхүүгийн сахилга батыг төлөвшүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн болно.

### **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, зорилгод хүрэх байдал буюу “зээлжих зэрэглэлт тогтоох аргачлал, журмыг эрх бүхий байгууллагаар батлуулах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 3. Зохицуулалтын хувилбарууд:

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад нөхцөл үргэлжлэх зорилгод боломжгүй. байгаа хэвээр бөгөөд хүрэх	Зардал гарахгүй боловч асуудлаас үүдэн бий болж байгаа сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнгүй.
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зорилгод хүрэх боломжгүй	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулаг хийх нэмэлт зардал гарах боловч энэ талаар хийгдэж буй арга хэмжээ эерэг үр дагаврыг шууд богино хугацаанд үүсгэхгүй.	Үр дүнгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Төрөөс татвар болон өөр хэлбэрээр зохицуулах боломжтой боловч энэ нь зорилгод бүрэн нийцэхгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх нь тухайн зохицуулахыг зорьж байгаа харилцаанд тохиромжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй. Төрийн санхүүжилтээр асуудал шийдвэрлэгдэх боломжгүй.	Үр дүнгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Тухайн зохицуулахыг зорьж байгаа харилцаанд тохиромжгүй. Эрх бүхий байгууллага хэрэгжүүлэх нь тохиромжтой.	Эрх бүхий байгууллагын чиг үүрэгт хамаарах тул илүү зардал гарахгүй.	Үр дүнгүй.
6	Захиргааны шийдвэр гаргах	Тусгай эрх бүхий байгууллагаар нэгдсэн аргачлал, журам батлах боломжтой боловч одоогийн мөрдөгдөж буй хуулиар зохицуулалт тодорхойгүй байна.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж чадахгүй.	Үр дүн бага.

7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Асуудлыг зохицуулах байгууллагуудын чиг үүрэг илүү тодорхой болж, үйл ажиллагааны нийцэл хангагдах ба олон нийтийн эрх ашгийг хамгаалах эрсдэлд суурилсан аргачлалтай болох эрх зүйн орчин сайжирснаар зорилгод хүрэх боломжтой.	Эрх бүхий байгууллагын чиг үүрэгт хамаарах тул илүү зардал гарахгүй	Үр дүнтэй.
---	--------------------------------------	--	---	------------

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсанаар банк, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ, удирдлагад суурилсан үйл ажиллагаа сайжирч, зээл, санхүүжилт нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Нэг талаас зээлдүүлэгч эрсдэлгүй, зөв шийдвэрийг шуурхай гаргах боломжтой болж, банк, санхүүгийн салбарын хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ буурах ба нөгөө талаас зээлдэгч өөрийн зээлийн түүхийг хянан удирдаж, санхүүгийн менежментээ зөв хийж эхлэх ба санхүүгийн сахилга хариуцлага сайжирна. Зээлдэгчийн зээлийн түүхийн мэдээлэл боловсронгуй болсноор Монгол Улсын бүртгэл мэдээллийн тогтолцоонд ахиц, дэвшил гарах юм. Зээлдэгчийн зээлийн мэдээллийг нэг дороос авах нэгдсэн сан Монгол Улсад цогцоор нь бий болж хөгжүүлэхэд энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлт ихээхэн үүрэг гүйцэтгэх болно.

Иймд хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон эерэг ба сөрөг талыг зардал, үр өгөөжөөр харьцуулсны үр дүнд "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" нь асуудлыг шийдвэрлэх ганц хувилбар байгаа буюу хууль гаргах хэрэгцээ, шаардлагатай гэж үзсэн тул тандан судлах ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

## **ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг гаргалаа. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг аргачлалд заасан шалгуур асуултын дагуу тандан судалсан байдлыг хүснэгт 4,5,6-аас үзнэ үү. Мөн зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хуулийн төслийг 1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө; 2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг энэ хэсгээр нарийвчлан судаллаа.

- 4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- 4.1.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Зээлдэгчийн зээлийн мэдээлэлд үндэслэн зээлжих зэрэглэл тогтоох аргачлал, журмыг төрийн эрх бүхий байгууллагаар батлах зохицуулалт бий болсноор

зээлдэгчийн нэгдсэн үнэлгээг ашиглан банк, санхүүгийн салбарын үйлчилгээний өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж цаашлаад хадгаламж эзэмшигч, харилцагчийн банканд хадгалуулсан мөнгөн хөрөнгө, өмчийн эрхийг хамгаалах үр нөлөөтэй.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Сонгосон хувилбар нь түр тусгай арга хэмжээ биш.
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Холбогдох төрийн болон арилжааны банкны төлөөлөлтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Холбогдох төрийн болон арилжааны банкны төлөөлөлтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Шууд бус утгаараа нийт иргэдийн эдийн засгийн эрхийг хангахад чиглэгдэнэ.
1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд аливаа байдлаар харшлаагүй. Олон улсын жишигт нийцүүлсэн.	

	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Одоо мөрдөгдөж буй хуулиар зохицуулсан
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	Одоо мөрдөгдөж буй хуулиар зохицуулсан
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Одоо мөрдөгдөж буй хуулиар зохицуулаагүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Банк, санхүүгийн салбарын бүх л оролцогч талуудын эрх хамаарагдана.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн байдлаар ялгаж тодорхойлоогүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй	Тус харилцаанд хамааралгүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	Тус харилцаанд хамааралгүй.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Төрийн эрх бүхий байгууллага
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Тус харилцаанд хамааралгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Бүрдүүлэх нөхцөлийг хангуулахаар хуулийн төсөл боловсруулсан

#### 4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт учирч болох эрсдэлийг бууруулах үүднээс дэлхийн улс орнууд банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаатай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулж ирсэн. Үүний нэг жишээ бол зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох аргачлалыг баталж эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зээлдэгчийн зээлжих зэрэглэл, оноо тогтоож байна. Банк, санхүүгийн салбарт гарах ямарваа нэгэн шийдвэрийг тооцоолол, үндэслэлгүйгээр хэрэгжүүлбэл санхүүгийн зуучлал саатах, эдийн засгийн хямралд хүргэх хор уршигтай байдаг.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Төрийн эрх бүхий байгууллагаас нэгдсэн аргачлал, журамтай болсноор мэдээлэл ил тод болох нөхцөлийг бүрдүүлнэ
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжтой
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Нэгдсэн аргачлал, журамтай болсноор олон улсын жишигт нийцэн
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй	Төрийн эрх бүхий байгууллагын чиг үүрэгт нийцнэ.

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

#### 4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Зээлдэгч, зээлдүүлэгчийн харилцааг сайжруулах, мэдээллийн зөрүүтэй байдлаас бий болох үр дагаврыг бууруулах нөхцөлийг бүрдүүлж зээлжих зэрэглэлийн тогтсон аргачлалтай болгосноор банк, санхүүгийн салбарын үйлчилгээний хүртэмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагад суурилсан тогтолцоог бий болгох ач холбогдолтой.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

#### 4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Банк, санхүүгийн салбарын олон улсын зарчмыг мөрдөх, зээлдэгчийн хариуцлагыг төлөвшүүлэх тул байгаль орчинд ээлтэй салбарт санхүүжилт олгоход дэмжлэг болно.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн агаарын хэрэгслийн бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Энэхүү тандан судалгааны хүрээнд холбогдох аргачлалыг үндэслэн зээлдэгчийн зээлийн зэрэглэл буюу зээлдэгчийн онооны системийг тогтоох аргачлал, журмыг төрийн эрх бүхий байгууллага болох Монголбанкаас батлах зохицуулалтыг судалж үзэхэд “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” нь асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой хувилбар байна гэж дүгнэж байна. Зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох аргачлалыг Монголбанк баталж зээлдэгчийн мэдээллийн зээлийн лавлагаанд тусгах хугацааг зургаа хүртэлх жил болгосноор дараах ач холбогдолтой:

- Зээлийн мэдээллийг ашиглан зээлдэгчийн зээлжих зэрэглэл тогтоох нэгдсэн аргачлал, журамтай болно;
- Зээлийн эрсдэлийг удирдах нэгдсэн систем, бүтэц бий болно;
- Их өгөгдөл буюу зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийг ашиглан зээлжих зэрэглэлд хамаарах банк, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой;
- Банк, санхүүгийн салбарын оролцогч талуудын санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд зургаан жил тусгах гэсэн заалтыг зургаа хүртэлх жил болгох зохицуулалтаар банк, санхүүгийн салбарын хөгжил, нийгэм, эдийн засагт гарж буй өөрчлөлтүүдтэй уялдуулан зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах боломжтой болно. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлжих зэрэглэл тогтооход ашиглах, зээлдэгчийн зээлжих зэрэглэл тогтоох аргачлалыг эрх бүхий бодлого тодорхойлогч байгууллагаар батлуулснаар банк, санхүүгийн салбарын хүртээмж буюу эрсдэлийн үнэлгээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн.